



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**Аудитыг дуусвар болгосон
тухай тайлан**

АГУУЛГА

ХУУДАС

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер: Ц.Ойдов
Утас: 260512

Аудитор: Ш.Отгонбаяр
С.Бат-Эрдэнэ
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.mnao.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 4: Зардлын гүйцэтгэлийн
тайлан

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮАГ-САГ/2014/20-СТА-ТТЗ

Оршил

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаархи зөвлөмжийг тусгасан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан судалгаа, шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Бидний олж илрүүлсэн асуудлын чиглэлд холбогдох хууль тогтоомж, заавар, журмын мөрдөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Асуудал 1 Ахмадын сангийн талаар

ИНЕГ-ын даргын 2010 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн А/355 тоот тушаалд Ахмадын сан байгуулах журам баталсан байна. Журмын 2.1.1-д байгууллагын тухай жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс цалингийн нийт сангийн 3,0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн эх үүсвэртэй байхаар заасан, мөн 3.1.1-д Ахмад настанд сар бүр 30,0 мянган төгрөгийн нэмэгдэл олгоно гэжээ. Гэтэл ахмадийн сангийн эх үүсвэр байхгүй нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардлаас 231.4 сая төгрөг зарцуулсан байна.

Асуудал 2 Хүүхдээ асрахад олгосон тэтгэмжийн талаар

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хүүхэдээ асарч байгаа нэг эхэд үндсэн цалингийн 70 хувь болох 267,2 сая төгрөгийн тэтгэмж 87 эхэд олгосон байна. Энэ нь ямар эх үүсвэрээс тэтгэмж олгосон нь тодорхой бус зардал гаргасан байна. Гэтэл хүүхэдээ асарч байгаа эх чөлөөтэй байх хугацаанд нь ажиллаж байгаа түр ажилтнуудтай цалингийн давхардал үүсэж байна.

Асуудал 3. Мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар

ИНЕГ-ын харьяалалгүй Зам тээврийн яаманд ажилладаг нэр бүхий 5 хүнд 39,1 сая төгрөгийн томилолтын зардал гаргасан, ба байгууллагын ажиллагсдын цай, кофе, сахарын хангалтад 17,8 сая төгрөг зарцуулсан байна.

ИНЕГ нь Мобиком, Юнитель ХХК-иудтай гэрээ байгуулж ажилчдын гар утасны төлбөрт 309,1 сая төгрөг шилжүүлж, дараа нь ажилчдын цалингаас суутгасан байна.

Асуудал 4. Үр дүнгийн шагнал олгосон талаар

ИНЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/742 тоот тушаалд түүний харьяа байгууллагуудын үндсэн ажилтанд жилийн эцсийн ажлын үр дүнг харгалзан олгох урамшуулалын хэмжээг хавсралтаар баталсан байна. Гэтэл хөдөлмөрийн дотоод журмын 1.8.2, 1.8.3-д заасныг зөрчиж, Сэргээн засал, сувилалын цогцолборын захирал ажилтнуудаа ажлын үр дүнгийн урамшуулал олгохдоо харилцан адилгүй 18.3 сая төгрөг олгожээ. /хавсралтаас үзнэ үү/

Асуудал 5. Санхүүгийн “Макс” програмын талаар

ИнфоСистемс” ХХК-тай 2001 оноос одоог хүртэл санхүүгийн “МАКС” програмыг НББ-ийн үйл ажиллагаанд ашигладаг. **Макс програмын алдаа болон сул талууд:** авлага өглөгийн үлдэгдэл хасах гарах, цалингийн тохиргоо болон олгодсон урьдчилгаа цалин алга болдог, урьдчилгаа аваагүй хүнээс суутгагддаг, зарим тохиолдолд баазууд нь өөр байдаг, орлого үр дүнгийн тайланг хураангуйгаар гардаг ба дэлгэрэнгүйг өөр тусдаа програмаар гаргадаг. Мөнгөн гүйлгээний тайлан гаргадагүй байна. Рестораны хоол үйлдвэрлэлийн өртөгийн тайланг Excel програмд гараар шивдэг. Каргогийн ачаа шуудан, түрээс, нислэгийн бүртгэлийн орлогын бүртгэл санхүүгийн програмтай уялдаагүй байна.

Асуудал 6. Үндсэн хөрөнгийн талаар

Аймгуудын нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, Сэргээн засал, сувилалын цогцолбор, Чингис хаан ОУ-ын нисэх буудал, ИНЕГ-ын харьяа газрын үйлчилгээний алба, Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын газар гэсэн эдгээр байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлийг агентлаг дээр төвлөрүүлэн бүртгэж, зөвхөн элэгдлийн зардлыг хуваарилсан байна. Тухайлбал Сэргээн засал, сувилалын цогцолбор нь үндсэн хөрөнгөнд бүртгэх хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, Газрын үйлчилгээний алба үндсэн хөрөнгийн элэгдлийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан зөрчлүүд байна.

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Асуудал 7. ИНЕГ “SABO” нийгэмлэгтэй гэрээ байгуулсан болон Гадаадад суралцаж буй оюутны сургалтын төлбөрийн талаар

ИНЕГ-ын дарга асан С.Батмөнх, Хойд Америкийн боловсролын нийгэмлэг “SABO” институтын ерөнхийлөгч Ж.Гордон нар 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №104/01 тоот гэрээ байгуулж, гэрээний урьчилгаа болох **1,631,238 ам. доллар шилжүүлсэн байна.** ИНЕГ-ын даргын. 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/399 тоот тушаалаар С.Энх-Амгалан, Н.Мөнхсүрэн нар томилолтоор АНУ-ын Лос-Анжелес, Сан Франциско, Карлсба, Канад, Ванкувер, Калгари, Бурнаби хотуудад Иргэний нисэхийн ерөнхий чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын сургалтын явцтай танилцсан тайлангаас харахад тус нийгэмлэгээс сургуулиудад төлсөн төлбөрийн дүн нь 724.063,3 ам.доллар байна. Энэ нийгэмлэг нь 1 хүний өмч бөгөөд тухайн нийгэмлэгийн үүсгэн байгуулагч нь Батсүх овогтой Батжаргал гэгч иргэн байна. ИНЕГ нь оюутан сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан оюутан шалгаруулж явуулаагүйгээс зарим оюутнууд үндсэн ангидаа оролгүй хэлний ангид сурдаг байна. Үүнээс ИНЕГ-ын зардлаар гадаад суралцагчдаас 10 оюутан төгссөж ирсэн байна. Үүнээс тус газарт 5 төгсөгчийг ажлын байраар хангасан, нэг төгсөгч хувийн авиакомпанид ажилд орсон, 4 төгсөгчтэй эргэж холбогдоогүй байна. ИНЕГ-ын урьд нь ажиллаж байсан удирдлагууд “SABO” институттэй тооцоо хийддэггүй ба хариуцлагагүй ажилласан байна. 2013 онд “SABO” нийгэмлэгт урьдчилж төлсөн төлбөрөөс 315,5 сая төгрөгийг сургалтын зардалруу бүртгэсэн байна.

Аудитын явцад сургалтын төлбөрийн тооцоог нотлох боломжгүй ба “SABO” институттэй хийсэн гэрээг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулах

Асуудал 8. Орон сууцны хөнгөлөлтийн талаар

С.Энх-Амгалан 30,0 сая төгрөг авсан ба урьд нь байр авсан байжээ.

Хөдөлмөрийн дотоод журмын 3.3.3.в-д урьд өмнө улсын болон төрийн өмчийн аль нэг байгууллага, иргэний нисэхийн салбар байгууллагуудаас орон сууц авч байгаагүй гэж заасныг зөрчсөн байна.

Гэтэл ИНЕГ-ын даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн А/678 тоот тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.3 дахь хэсгийг хүчингүй болгосон байна.

Энэ нь Ажил олгогч, ажилтны төлөөлөл, болон Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хэлэлцэж, “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулах талаар заагаагүйгээс зөвхөн удирдлагын зөвлөлөөр дээрх журамд өөрчлөлт оруулсан байна.

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Асуудал 8. Авлага, өглөгийн талаар

Гадаадын авиа компани 7,400,6 сая, гадны байгууллагаас 206,7 сая нийт 7,607,3 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Тендертэй холбоотой банкинд байршуулсан 2,288.7 сая төгрөгийн өглөг байна.

Асуудал 9. Үл хөдлөх хөрөнгийн талаар

Үл хөдлөх хөрөнгийн татварт 583,8 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 688,8 сая төгрөг зарцуулж , 105,0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Эдгээр нь дараах хуулийн заалтууд болон батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна. Тухайлбал:

- **ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 3.3.3.а-д:** “байгууллагын үндсэн ажилтан байна”, **3.3.3.б-д:** “ИНЕГ, түүний харъяа байгууллагад болон иргэний нисэхийн системийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байна”,
- **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д:** “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”,
- **Иргэний нисэхийн тухай хуулийн 8.4.5-д:** “иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах”,
- **Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.2-д:** Амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсэн нэг хүртэлх насны хүүхэдтэй эх өөрөө хүсвэл түүнд хүүхдээ асрахад нь зориулж ,сар тутамд үндсэн цалингийн 70%-тай тэнцэх хэмжээний чөлөө олгож, чөлөөтэй байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төлнө”
- **Үнэн зөв байдал:** “ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллага, хууль тогтоох байгууллага, СЯ-наас гаргасан дүрэм журамд нийцэж байх” гэсэн батламж мэдэгдэл болон дээрх хуулийн заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: Аудитаар нийт 10,967.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэний **7,458.0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5 зөвлөмж өгөгдсөн, болно. Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад холбогдох хууль тогтоомж, заавар, журмыг баримталж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аймгуудын нисэх буудлууд болон харьяа 12 байгууллагууд зөрчилгүй санал дүгнэлт авсан ба Тосонцэнгэл, Ховд аймгийн нисэх буудлын санхүүгийн тайланд

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

аудит хийгээгүй байна. Увс, Хөвсгөл аймгийн нисэх буудал хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Увс аймгийн "Дэглий цагаан нисэх буудал" ТӨААҮГ-т ашиглагдаж байгаа 20,2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн тайлант үеийн зардлыг тодруулгад тусгаагүй ба 833,1 сая төгрөгийн элэгдлийн зардлын тооцооллыг хянаж үзэх боломжгүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдснөөс 1 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжээгүй байна. 690,0 сая төгрөгийн акт тавьснаас 150,0 сая төгрөгийг чөлөөлж 540,0 сая төгрөгийн акт биелээгүй, бөгөөд эдгээр акт, зөвлөмжийн биелэлтийг гаргасан байна.

Аудитын санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөхийг Газрын даргад санал болгож байна.



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2

| | |
|--------------------------------------|--|
| Асуудал 1 | Ахмадын сангийн талаар |
| Асуудал 2 эхэд талаар | Хүүхдээ асарч байгаа олгосон тэтгэмжийн |
| Асуудал 3 | Мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар |
| Асуудал 4 | Үндсэн хөрөнгийн талаар |
| Асуудал 5 | Санхүүгийн"МАКС" програмын талаар |

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Иргэний нисэхийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан ИНЕГ-ын дарга Т.Лхагвасүрэн, Ерөнхий нягтлан бодогч М.Энхмаа болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

1. ИНЕГ-ын даргын 2010 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн А/355 тоот тушаалд Ахмадын сан байгуулах журам баталсан байна. Журмын 2.1.1-д байгууллагын тухай жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн эх үүсвэртэй байхаар заасан , мөн 3.1.1-д Ахмад настанд сар бүр 30.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгоно гэжээ. Гэтэл ахмадийн сангийн эх үүсвэр байхгүй нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардлаас 231.4 сая төгрөг гаргасан байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх \Э,Иж,Т\

ҮАГ-ын зөвлөмжүүд

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

ҮАГ-ын ажиглалт

Хүүхэдээ асарч байгаа 87 эхэд 267.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Ямар эх үүсвэрээс тэтгэмж олгосон нь тодорхой бус зардал гаргасан байна. Тухайн хүүхэдээ асарч байгаа эх чөлөөтэй байх хугацаанд нь ажиллаж байгаа ажилтнуудтай цалингийн давхардал үүсгэсэн байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх \Э,Иж,Т\

ҮАГ-ын зөвлөмжүүд

Цаашид төлөвлөгдөөгүй зардал гаргахгүй байх, Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг зогсоох.

Үйлчлүүлэгчийн хариу

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын ажиллагсдын цай, кофе, сахарын хангалтад 17,8 сая төгрөг зарцуулсан,

Үл хөдлөх хөрөнгийн татварт 583,8 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 688,8 сая төгрөг зарцуулж, 105,0 сая төгрөгөөр хэтэрсэн,

Мобиком, Юнитель ХХК-иудтай гэрээ байгуулж ажилчдын гар утасны төлбөрт байгууллагаас 309,1 сая төгрөг шилжүүлсэн,

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх
\\Э,Иж,Т\

ҮАГ-ын зөвлөмжүүд

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг давтан гаргахгүй байх.

Батлагдсан зардлыг хэтрүүлэхгүй байх, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн этгээдүүдийн үл хөдлөх хөрөнгө; 7.1.4 –д үйлдвэрлэл , технологийн парк доторхи барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгө гэж заасантай нийцэхгүй байгааг ЗТЯ-нд дээрх асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

ҮАГ-ын ажиглалт

Аймгуудын нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэл, Сэргээн засал, сувилалын цогцолбор, Чингис хаан ОУ-ын нисэх буудал, ИНЕГ-ын харьяа газрын үйлчилгээний алба, Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын газар гэсэн эдгээр байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлийг агентлаг дээр төвлөрүүлэн бүртгэж, зөвхөн элэгдлийн зардлыг хувиарласан байна. Тухайлбал СЗСЦ-нь үндсэн хөрөнгөнд бүртгэх хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, Газрын үйлчилгээний алба үндсэн хөрөнгийн элэгдлийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх \Э, Иж, Үз, Х\

ҮАГ-ын зөвлөмжүүд

Агентлагийн харьяа байгууллагуудын элэгдлийн зардлыг 2014 оноос хувиарлахгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

ҮАГ-ын ажиглалт

“ИнфоСистемс” ХХК-тай 2001 оноос одоог хүртэл санхүүгийн “МАКС” програмыг НББ-ийн үйл ажиллагаанд ашигладаг. Макс програмын алдаа болон сул талууд: авлага, өглөгийн үлдэгдэл хасах гарах, цалингийн тохиргоо болон олгодсон урьдчилгаа цалин алга болдог, урьдчилгаа аваагүй хүнээс суутгагддаг, зарим тохиолдолд баазууд нь өөр байдаг, орлого үр дүнгийн тайланг хураангуйгаар гардаг ба дэлгэрэнгүйг өөр тусдаа програмаар гаргадаг. МГ-ний тайлан гардаггүй байна. Рестораны хоол үйлдвэрдэлийн өртөгийн тайланг Excel програмд гараар шивдэг. Каргогийн ачаа шуудан, түрээс, нислэгийн бүртгэлийн орлогын бүртгэл

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх
\Э,Иж,Т\

ҮАГ-ын зөвлөмжүүд

ИНЕГ-нь санхүүгийн сайн боловсруулсан цогц үйлчилгээтэй програм худалдан авах шаардлагатай.

Үйлчлүүлэгчийн хариу



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 3/484
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн үлдэгдлийн тэнцэл, орлогын тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, Агентлагийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

- Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас ахмадуудад сар бүр 30.0 төгрөгөөр тооцон нийт 265 ахмадуудад 231.4 сая төгрөгийг олгосон байна.
- Цалингийн давхардал үүсгэн хүүхэдээ асарч байгаа нэг эхэд сар бүр үндсэн цалингийн 70 хувиар тооцон 87 эхэд 267,2 сая төгрөгийн тэтгэмж олгосон.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд Үндэсний аудитын газраас 540.0 сая төгрөгийн төлбөрийн акт тавьсан боловч барагдуулаагүй.

- “SABO” институттэй байгуулсан гэрээний дагуу 2012 онд шилжүүлсэн урьдчилгаа төлбөрөөс 2013 онд 315,2 сая төгрөгийг сургалтын зардлаар тооцож бүртгэсэн боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Гадаадын авиа компаниудаас авах авлага 7,400,6 сая, гадны байгууллагаас авах авлага 206,7 сая нийт 7,607,3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийн тэнцэл, орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХЗАЯА